



ШШГЕГ-ЫН ХАРЬЯА ХОРИХ 403-Р АНГИ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

Лавлах зүйлс байвал доорх хаягаар

холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Аудитын менежер

Т.Майцэцэг

Утас: 70273465

И-мэйл

Аудитор

О.Сосор

Утас: 70273204

И-мэйл

АГУУЛГА

ХУУДАС

• Танилцуулга	1-7
• Санхүүгийн дотоод хяналт	7
• Гол шийдлүүд	8
• Залруулаагүй алдаа	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	8
• Аудитын санал дүгнэлт	8-

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

ШШГЕГ-ын харьяа Хорих 403-р ангийн

2013 оны Санхүүгийн Тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Хорих 403-р ангийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Хорих 403-р ангийн төсвийн ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Хорих 403-р ангийн Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад Зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна.

Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 оны урсгал санхүүжилт 823768.9 мянган төгрөгөөр батлагдсан байна. 2013 онд батлагдсан төсвийг 16105.5 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 807663.4 мянган төгрөгийн урсгал санхүүжилт олгосон байна. Туслах үйл ажиллагааны орлого 690.0 мянган төгрөг харилцах дансанд орсон байна. Ялтны хөдөлмөрийн хөлсийг орлого 55652,7 мянган төгрөгийг тайлан тэнцэлд тусгасан байна.

Мөнгөн харилцахын журналаас sort filter – ийг ашиглан эх үүсвэрийг тайлан тэнцэлд тусгасаныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд орлого, санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

- Цалингийн зардлаас 3528.0 мянган төгрөгийг шатахууны зардалд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73-р төсвийн захирагчийн төсөвт

зохицуулалт хийх журмын 7.2.3-т “цалин хөлс нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг бусад зардалд шилжүүлэхийг хориглоно „гэсэн заалтыг зөрчсөнд акт бичигдсэн.

- Цалин хөлсний баримтыг шалгахад ангийн дарга, дэд дарга, ахлагч төлөөлөгч,төлөөлөгч нарын нэмэгдэлийн дүн нь нийт бодогдсон цалингийн 40 хувиас хэтэрч байна. Энэ нь Засгийн газрын 1995 оны 96-р тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох журмын 3.т “Төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох бүх төрлийн нэмэгдлийн нийт хэмжээ нь төрийн захиргааны болон тусгай албаны албан хаагчийн хувьд түүний албан тушаалын сарын цалин ,бүх төрлийн нэмэгдлийн дүнгийн 40 хувиас хэтрэхгүй байна ,гэсэн заалт зөрчигдөж байна.

- Төрийн санд хүсэлт гаргалгүй түлш халаалтын зардлаас 1752.0 мянган төгрөгийг шатахуунд, хоолны зардлаас 191.9 мянган төгрөгийг шатахуунд, 432.0 мянган төгрөгийг томилолтын зардалд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам,-ын 5.2-дахь заалтыг зөрчсөн байна.

- ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан
талаар тайлбар ирүүлнэ үү

Санхүүгийн тайлангийн аудитаар ажлын баримтанд үндэслэн 8004.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Нийт зөрчил нь материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа.

Аймгийн Ерөнхий Аудитор 2014 оны 02-р сарын 09-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч О.Манлай олон бусад бидэнтэй хамтран ажилласан ажиллагсдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Аудитор

О.Сосор

Төв аймгийн Аудитын Газар

2014.01.27

Танилцуулга

1. Бид Хорих 403-р ангийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Хорих 403-р ангийн даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Хорих 403-р ангийн тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Хорих 403-р ангийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Хорих 403-р ангийн даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Хорих 403-р ангийн удирдлагын анхаарлыг хандуулж байна.

1 .Орлого,санхүүжилтийн талаар

Батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад Зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна. Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 онд батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад Зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна. Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 оны урсгал санхүүжилт 823768.9 мянган төгрөгөөр батлагдсан байна. 2013 онд батлагдсан төсвийг 16105.5 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 807663.4 мянган төгрөгийн урсгал санхүүжилт олгосон байна. Туслах үйл ажиллагааны орлого 690.0 мянган төгрөг харилцах дансанд орсон байна. Ялтны хөдөлмөрийн хөлсийг орлого 55652,7 мянган төгрөгийг тайлан тэнцэлд тусгасан байна. Мөнгөн харилцахын журналаас sort filter –ийг ашиглан эх үүсвэрийг тайлан тэнцэлд тусгасаныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд орлого, санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

2. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн 2013 оны эхний үлдэгдэл 1397757.5 мянган төгрөг, тайлант онд үндсэн хөрөнгө нь 90945.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, данснаас 345.6 мянган

төгрөгийн хөрөнгө хасагдаж, оны эцэст 1497388.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хөрөнгийг хүлээн авсан акт шийдвэрийг үндэслэн дараахь хөрөнгийг орлогодсон байна. ШШГЕГазраас нэгдсэн хангалтаар 9030.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ирснийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

Төрийн өмчийн хорооны 2013.11.21 ны өдрийн 630 тоот тогтоолоор 15956.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5646.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авах зөвшөөрөл олгосноор төсвийн хөрөнгөөр 24603.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч данс бүртгэлд тусгасан байна. 60894.4 мянган төгрөгийн барилга засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Төрийн өмчийн хорооны 2013.07.05 ны өдрийн 465 тоот тогтоолоор ШШГЕГазрын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадад бүртгэлтэй хөрөнгүүдийг аклах шийдвэр гарч газ 53 маркийн, 07-84ТӨА улсын дугаартай, 345.6 мянган төгрөгийн дансны үнэтэй автомашиныг актлах, сэлбэгээр ашиглах шийдвэр гарч данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг Хорих 403-р ангийн даргын 2013.12.13 ны өдрийн А/53 тоот тушаалаар 9 хүний бүрэлдхүүнтэй тооллогын комиссын даргаар Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, хошууч А.Эрэнбатыг томилсон байна. Тооллогын комиссууд тооллогыг хийж илтгэх хуудсаар дүнг танилцуулсан байна. Нягтлан бодогч хөрөнгийн тооцоог бодож акт үйлдсэн байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолын дагуу шулуун шугамын аргаар тооцсон.

3. Бараа материал

Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна.

Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага, өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 110599.4 мянган төгрөг, орлого 274689.0 мянган төгрөг, зарлага 274773.0 мянган төгрөг гарч 110515.5 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансанд хөтлөгдөх анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад тайлан гаргалт, баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудас зэргийг зохих журмын дагуу холбогдох албан тушаалтан гарын үсэг тамга тэмдэг дарагдсан эсэхийг шалгахад албажсан байна.

УСНББОУС-12-ыг зөрчиж 25189.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнд бүртгэсэн зөрчил илэрсэн.

Бараа материалын дансанд оны эхэнд 13730.0 мянган төгрөг, тайлангийн хугацаанд 10000.0 мянган төгрөгийн 100 толгой малыг худалдан авсан байна. Эргэлтийн хөрөнгөнд 27 толгой үхэр, 31 толгой адуу, хонь 106 толгой, ямаа 82, нийт 246 толгой мал 24745.0 мянган төгрөгийн бүртгэлтэй байна. Нүүрсийг Цагийн аяс ХХК-иас 600 тонн нүүрс худалдан авч тайлангийн хугацаанд 1060.2 тн нүүрсийг уурын зууханд зарцуулсан байна.

ШШГЕГазрын 2013.12.10 ны өдрийн А/223 тоот тушаалын дагуу 6631.1 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлаж данс бүртгэлээс хассан байна.

4. Цалингийн талаар

Цалингийн зардал Мөнгөн гүйлгээний тайланд 412945.7 мянган төгрөгөөр үр дүнгийн тайланд 412945.7 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Цалингийн зардлыг sort filter –ийг ашиглан түүвэрлэхэд шалгахад үр дүнгийн тайланд цалингийн зардлаас шатахуунд гүйлгэн зарцуулсан 3528.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Цалингийн зардлаас 3528.0 мянган төгрөгийг шатахууны зардалд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73-р төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 7.2.3-т *“цалин хөлс нэмэгдэл урамшуулал болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг бусад зардалд шилжүүлэхийг хориглоно* , гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хорих 403-р анги нь 2013 онд нийт 56 орон тоо батлагдсанаас, гүйцэтгэлээр 53 орон тоогоор ажилласан байна.

Цалин хөлсний бодолтыг шалгахад ангийн дарга, дэд дарга, ахлагч төлөөлөгч, төлөөлөгч нарын нэмэгдэлийн дүн нь нийт бодогдсон цалингийн 40 хувиас хэтэрч байна. Засгийн газрын 1995 оны 96-р тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох журмын 3.т *“Төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох бүх төрлийн нэмэгдлийн нийт хэмжээ нь төрийн захиргааны болон тусгай албаны албан хаагчийн хувьд түүний албан тушаалын сарын цалин ,бүх төрлийн нэмэгдлийн дүнгийн 40 хувиас хэтрэхгүй байна* , гэсэн заалт зөрчигдөж байна.

5.Бараа үйлчилгээний зардал

Бараа ажил үйлчилгээний зардал нь төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төлөвлөгөөгөөр 386250.9 мянган төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 384497.4 мянган төгрөгөөр буюу 1753.5 мянган төгрөгөөр хэмнэлттэй байна.

Шатахууны зарцуулалтын байдлыг шалгаж үзэхэд жолоочийн тооцооны хуудас хөтөлдөггүй, шатах тослох материал олгох баримт гэсэн хуудсаар албан ажлын явах чиглэл, зарцуулах шатахууныг бичиж шатахууныг олгодог зөрчил илэрсэн.

Түлш халаалтын зардлаас 1752.0 мянган төгрөгийг шатахуунд, хоолны зардлаас 191.9 мянган төгрөгийг шатахуунд, 432.0 мянган төгрөгийг томилолтын зардалд төрийн санд хүсэлт гаргалгүй гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5.2-дахь заалтыг зөрчсөн байна. Дээрхи зардлуудын гүйцэтгэлийг үр дүнгийн тайланд бодит байдлаар тайлагнасан байсан.

6.Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн байна. Цалин хөлсийг бэлнээр тавьж олгодог. Хүнсний материалыг бэлэн мөнгөөр худалдан авч байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар батлагдсан “төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”, -ыг баримтлан ажиллаагүй байна. Хорих 403-р анги нь төсвийн харилцах, ялтнуудын нэрийн дансны харилцах гэсэн 2 харилцах данстай. Харилцах данснуудын үлдэгдлийг төрийн сангаар баталгаажуулсан .Ялтнуудын нэрийн данс 15162.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь төрийн сангийн үлдэгдэлтэй тохирч байна.

7.Авлага ,өглөгийн талаар

Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтрийн данстай тулган баталгаажуулсан. Ажил гүйлгээг тухай бүрд нь өглөг, авлаг үүсгэн бүртгэсэн. Харилцагч байгууллагуудаас НДХэлтэс, Цагийн аяс ХХК, Эрчим хүчний салбартай тооцоо нийлж актыг үйлдсэн боловч тооцооны баримтын жагсаалт хийгээгүй байна. Тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтанд нэгтгэн гаргахгүй байгаа нь нийт төлсөн мөнгө болон бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжилсэн дүн тодорхой бус байна.

8. Санхүүгийн дотоод хяналтын талаар

МУ-ын ЗГЗрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэж заасны дагуу байгууллагад дотоод хяналт шалгалтыг хэрхэн хийж байгаа талаар шалгахад байгууллагын дотоод хяналт шалгалт хийх комиссыг Хорих 403-р ангийн даргын 2013.08.05ны өдрийн А/36 тоот тушаалаар байгуулж, дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг баталж, батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг явуулж тайланг бичсэн байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Хорих 403-р ангийн удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар залруулаагүй алдаа гараагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.02.08